МЭДЭЭ · 2020 оны 1-р сарын 20

НАЛАЙХ, БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТЫГ СУДАЛЖЭЭ



Налайх, Багахангай дүүргийн прокурорын газраас тус дүүргүүдийн хэмжээний эрүүгийн нөхцөл байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг 2019 оны байдлаар судалжээ. Судалгаагаар Налайх дүүргийн хэмжээнд 2019 онд нийт 319 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 73 хэргээр буюу 18,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл хүнийг санаатай алах гэмт хэрэг 5 гарсан нь өмнөх оноос 1 буюу 25 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 2 буюу 66,6 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 8 буюу 72,7 хувиар тус тус өссөн бол хулгайн гэмт хэрэг 47 буюу 35,6 хувиар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 15 буюу 10,6 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 5 буюу 80 хувиар тус тус буурчээ. Нийт гэмт хэргийн 72 хувийг хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг болон хулгайн гэмт хэрэг эзэлж байна.

Багахангай дүүргийн хэмжээнд 2019 онд 26 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7 буюу 21,2 хувиар буурсан бол хулгайлах гэмт хэрэг 3 буюу 40 хувиар, хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5 буюу 41 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3 буюу 25 хувиар тус тус буурчээ.

Харин хүчиндэх гэмт хэрэг 2 буюу 2 дахин өссөн бол 2018 онд үйлдэгдээгүй байсан гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 5, залилах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн байна. Гэмт хэргийн гаралтаас үзэхэд тус дүүргийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон хүчиндэх гэмт хэрэг нийт хэргийн 61,5 хувийг эзэлж байгаа бол эдгээр гэмт хэргүүдийн 87,5 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

Тухайлбал: 2019 онд тус дүүрэгт эх нь архидан согтуурсан үедээ өөрийн 6-10 насны 2 хүүхдийг галын дэгээ төмрөөр хайрах, цахилгааны утсаар ороолгох, унины модоор цохих зэргээр удаа дараа зодож, зовоон тарчлаах байдлаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хэрэг гарсан байна.

Дүүргийн прокурорын газраас судалгааны дүнг үндэслэн Налайх, Багахангай дүүргийн төр захиргааны удирдлага болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах зөвлөлийн зүгээс дээрх байдалд анхаарч, дүүргийн хэмжээнд ажилгүйдлийг бууруулах, архидан согтууралттай хийх тэмцлийг эрчимжүүлэх, залуучуудын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах, зонхилон гарч буй хулгайн болон хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх цогц арга хэмжээг боловсруулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай талаар албан бичиг хүргүүлж, дүүргийн болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах зөвлөлийн 2020 оны төлөвлөгөөнд тодорхой ажлуудыг тусгуулах талаар санал хүргүүлсэн байна.

НАЛАЙХ, БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2972